

**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1. Энэхүү журмын зорилго нь Э-Транс Ложистикс хувьцаат компани (цаашид “компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) болон хуульд заасан бусад эрх бүхий байгууллагад хүргүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй компани нь энэхүү журамд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэж, зохион байгуулна.

1.3. Компани нь ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахдаа энэхүү журмыг баримтлан хурлын зарыг хүргэнэ.

**ХОЁР. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ  
ТУХАЙ ШИЙДВЭР ГАРГАХ**

2.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуулийн 59.4-т заасан хугацаанд зарлан хуралдуулах үүрэгтэй.

2.2. Компанийн ээлжит бус хурлыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, компанийн нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч (цаашид “хурал зарлагч этгээд” гэх) Компанийн тухай хуулийн 61.1 болон компанийн дүрэмд заасан бусад үндэслэлээр хэдийд ч зарлан хуралдуулж болно.

2.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрт Компанийн тухай хуулийн 60.2-т заасан зүйлийг заавал тусгана.

2.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно.

2.5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Компанийн тухай хуулийн 64.2-т заасны дагуу хурал зарлагч этгээд тогтоох бөгөөд энэ өдөр нь энэхүү журмын 3.5-д заасны дагуу хурал хуралдуулах тухай зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 10 дахь өдөр байхаар тогтооно.

2.6. Хурал зарлагч этгээд нь хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрийг гаргаснаас хойш 3 хоногийн дотор энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК /цаашид “Хөрөнгийн бирж” гэх/-д хүргүүлнэ.

2.7. Энэхүү журмын 2.6-д заасан мэдэгдэлд дараахь баримт материалыг хавсаргасан байна.

2.7.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр,

2.7.2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар,

2.7.3. Саналын эрх бүхий энгийн хувьцааны буюу түүнээс дээш хувийг эзэмшигч байгаа хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 66.1-т заасны дагуу хурлын хэлэлцэх асуудалд санал оруулсан бол түүний хуулбар,

2.7.4. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа,

2.8. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгосн хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь хуралд оролцоно.

2.9. Бүртгэлийн өдрөөс хойш хувьцаагаа бусдад шилжүүлсэн этгээд, шинэ эзэмшигч этгээдэд хуралд оролцох итгэмжлэл олгох, эсхүл уг шинэ эзэмшигч этгээдийн өгсөн зааврын дагуу санал өгч болно.

2.10. Компани нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг гаргасан шийдвэрийн хамт 6 дугаар сарын 01-ний дотор, ээлжит бус хурлын материалыг хурал хуралдсанаас хойш 20 хоногийн дотор Хороонд ирүүлэх үүрэгтэй.

2.11. Компани нь энэ журмын 2.10-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг ирүүлээгүй бол Хороо ажлын 10 хоногийн дотор Компанийн тухай хуулийн 59.7-д заасны дагуу энэ тухай нийтэд мэдээлнэ.

2.12. Хуралтай холбоотой мэдээллийг Хорооноос өгөх эсхүл хурал хуралдуулахтай холбоотой маргаан гарсан тохиолдолд энэ журамд заасны дагуу Хороонд ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, хурлын материал, түүнээс гарсан шийдвэр болон холбогдох бусад баримт материалыг эх хувь болгон ашиглана.

### **ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАРЫГ ХҮРГЭХ**

3.1. Хурал зарлагч этгээд энэ журмын 2.6-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт Хороонд ирүүлсний дараа хувьцаа эзэмшигчдийн хурлын тухай зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.

3.2. Компанийн тухай хуулийн 60.4-т заасны дагуу хувьцаа эзэмшигчийн хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг гарснаас хойш 5 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг энэ журмын 3.1-т заасны дагуу нийтэд мэдээлнэ.

3.3. Хурал зарлагч этгээд нь хурлын зарыг хурал хуралдахаас 30 болон түүнээс багагүй хоногийн өмнө өдөр тутмын 2-оос доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевиз болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчиддээ мэдээлнэ.

3.4. Энэ журмын 3.3-т заасан мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлнэ.

3.5. Хурал зарлагч этгээд нь хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг энэ журмын 3.3-т зааснаас гадна утас, факс, электрон шуудан зэрэг холбоо харилцааны боломжит бусад хэрэгслийг ашиглан хувьцаа эзэмшигчдэд хүргэж болно.

3.6. Хурал зарлагч этгээд нь энэхүү журмын 2.5-т заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдөр гэдгийг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар нийтэд хүргэсэн өдрийг тооцно.

3.7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зард дараах мэдээллийн заавал тусгана.

3.7.1. компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар,

3.7.2. хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр,

3.7.3. хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт,

3.7.4. хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг,

3.7.5. хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь,

3.7.6. компанийн дүрэмд заасан болон хурал зарлагч этгээдээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

3.8. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан хурлын ирц хүрээгүй тохиолдолд энэ тухай тэмдэглэл, протокол үйлдэж, хйошлогдсон хурлын товыг тогтоож, хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гарган хурлыг хойшлуулна. Хурал хойшлогдсон тухай мэдэгдлийг холбогдох материалын хамт Хороонд ажлын 5 хоногт багтаан ирүүлнэ.

3.9. Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас 10 болон түүнээс багагүй хоногийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг энэ журмын 3.3-т заасан хэлбэр, шаардлагын дагуу дахин мэдээлнэ.

3.10. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хурлын зар мэдээг нийтэд анх хүргэсэн өдрөөс хойш 5 хоногт багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компанид хүргүүлнэ.

3.11. Компанийн ерөнхий захиргаа байрлаж байгаа газраас өөр газарт хурлыг хуралдуулахаар товлосон бол хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн хамгийн их төвлөлөлтэй, аливаа зардал, чирэгдэлгүйгээр оролцох боломжтой газарт хурлыг хуралдуулна.

3.12. Хуралд оролцоогүй, эсхүл эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч нь хурал зарлагч этгээдийг энэ журмын 2.4, 3.1-3.4, 3.7-д заасныг зөрчсөн гэж үзсэн Хороо хянаж үзээд үндэслэлтэй гэж үзвэл хувьцаа эзэмшигчдийн хурал, эсхүл тухайн шийдвэрийг Компанийн тухай хуулийн 70.2-т заасан эрх хэмжээний дагуу хүчингүйд тооцно.

### **ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА**

4.1. Энэ журмын 2.10-т заасныг зөрчсөн бол Хорооны үнэт цаасны гүйлгээний улсын байцаагч Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.1.1-т заасан журмын дагуу буруу этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

4.2. Энэ журмын 2.1-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулаагүй тохиолдолд компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дарга, гишүүд нь Компанийн тухай хуулийн 59.5, 59.6, 81.5.7-т тус тус заасан хариуцлага хүлээнэ.